



МӨНГӨНИЙ БОДЛОГЫН МЭДЭГДЭЛ

Дугаар: 2011/04

Огноо: 2011 оны 4-р сарын 27

Эмбарго: 2011 оны 4-р сарын 28-ны Пүрэв гаригийн 11:00 цаг хүртэл

Монголбанкны Захирлуудын зөвлөлийн 2011 оны 4-р сарын 27-ны өдрийн хурлаас Төв банкны бодлогын хүүг 0.5 нэгж хувиар нэмэгдүүлж, 11.5% болгох шийдвэр гаргалаа. Энэхүү шийдвэрийг гаргахдаа дараахь зүйлд үндэслэсэн болно. Үүнд:

- Улаанбаатар хотын инфляци 2011 оны 3-р сарын байдлаар жилийн 7.4% болсон нь зөвхөн махны үнийн бууралтаас шалтгаалсан огцом бууралт байв. Харин суурь инфляци буюу хүнсний бүлгийн гол барааг хэрэглээний сагснаас хасч тооцсон инфляци 2011 оны 3-р сарын байдлаар 7.9%-тай болж, ерөнхий инфляцийн түвшингээс өндөр боллоо. Суурь инфляци ийнхүү ерөнхий инфляцийн түвшингээс давж гарах нь мөнгөний илүүдэл нийлүүлэлтээс үүдэлтэй инфляци бий болж буйг харуулж байгаа юм.
- 2011 оны 3-р сарын байдлаар мөнгөний нийлүүлэлт өмнөх оны мөн үеэс 67%-иар буюу 1.98 их наяд төгрөгөөр өсч цаашид ч үргэлжлэн өсөх хүлээлттэй байна. Мөнгөний нийлүүлэлт ийнхүү хурдтай өсөхөд гадаадаас орж ирж буй хөрөнгийн урсгал гол үүргийг гүйцэтгэсэн бөгөөд мөнгөний энэхүү өсөлтийг даган зээл ч өндөр хувиар өсөх төлөвтэй байна. 2011 оны 3-р сарын байдлаар санхүүгийн системийн зээлийн өрийн үлдэгдэл өнгөрсөн оны мөн үеэс 35%-иар буюу 962 тэрбум төгрөгөөр өссөн бөгөөд энэ өсөлт цаашид улам эрчимжих хандлагатай байна. Зээлийн хурдтай өсөлт болон төсвийн өндөр зардал нь эргээд мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлж, энэ нь улмаар инфляцийг өсгөх дарамтыг учруулсаар байх болно. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн потенциал буюу үйлдвэрлэлийн боломжит түвшин өсч амжаагүй байхад түүнээс түрүүлээд мөнгөний илүүдэл нийлүүлэлтээс үүдэлтэй эрэлт бий болох нь эцсийн дүндээ зөвхөн бараа, үйлчилгээний үнийг л өсгөх үр дагавартай байх болно.
- Монголбанкнаас хийсэн инфляцийн урьдчилсан прогнозоор хэрэв дээрх байдал энэ чигээрээ үргэлжилвэл инфляци оны эцэст 15-20 хувийн хооронд гарах магадлалтай байна.

Ийнхүү манай улсын эдийн засагт хэт халалтын шинж тэмдгүүд илэрч эхлээд байна. Иймээс мөчлөг дагасан төсвийн бодлогоос зайлсхийж чадахгүй байгаа өнөөгийн нөхцөлд Төв банк мөнгөний бодлогыг чангаруулах зайлшгүй шаардлагатай тулгараад байна.

Төв банк бодлогын шийдвэр гаргахдаа зөвхөн статистик тоо мэдээллийн гүйцэтгэлд бус харин ирээдүйд хүлээгдэж буй инфляцийн тооцоололд илүүтэй үндэслэн бодит эрсдлийг урьдчилан харсаны үндсэн дээр уг эрсдлийг тулгарахаас нь өмнө сөрж арга хэмжээ авдаг гэдгийг онцлон тэмдэглэмээр байна. Өөрөөр хэлбэл Төв банкны мөнгөний бодлого зөвхөн өнөө маргаашийн нөхцөл байдлыг бус, харин илүү урагшаа, алсыг харсан байдаг.

Иймээс мөнгөний бодлогыг чангаруулж буй Төв банкны энэ арга хэмжээ нь нэгдүгээрт, дунд хугацааны макро эдийн засгийн хэт халалт бий болохоос урьдчилан сэргийлэх; хоёрдугаарт, эдийн засгийн огцом идэвхжилээс шалтгаалан нэмэгдэж буй суурь инфляцийн өндөр дарамтыг бууруулах замаар дунд хугацааны тогтвортой, тасралтгүй өсөлтийг хангах зорилготой ирээдүй рүү чиглэсэн арга хэмжээ юм.

МОНГОЛБАНК